МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр Дугаар А/83 Мөрөн сум

Томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/482 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын 2022 оны 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбогдуулан мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, саналыг үндэслэн Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Тосонцэнгэл, Хатгал, Цагааннуур, Цагаан-Үүр, Шинэ-Идэр, Мөрөн сумдын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн мөн оны 03 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд түр хязгаарлаж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллахыг холбогдох сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

2. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн дунд, бага ангийн хичээлээс гадуурх секц, дугуйлан, сургалтын төв, уралдаан, тэмцээний үйл ажиллагааг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн мөн оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд түр хязгаарлаж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Ганзориг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ч.Дашбаяр) нарт тус тус даалгасугай.

3. Томуу, томуу төст өвчний дэгдэлт 0-5 насны хүүхдүүдийн дунд их байгаа тул 0-5 насны хүүхэд нь уг өвчний халдвар авч эмчлүүлж байгаа албан хаагчиддаа байгууллагын хүний нөөцийн нөхцөл боломжтой уялдуулж, эмчийн магадалгааг үндэслэн цалинтай чөлөө олгох асуудлыг шийдвэрлэхийг аж ахуй нэгж, байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй.

4. Зарим сумдын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр хязгаарлаж байгаатай холбогдуулан хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг хүргүүлэн, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг холбогдох сумдын Онцгой комиссын дарга, Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Ганзориг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ч.Дашбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээлэл, сурталчилгааг иргэдэд тогтмол хүргэж, амьсгалын цочмог халдвар ихэссэн үед ор дэлгэх, эмнэлгийн бэлэн байдлыг хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр), Нэгдсэн эмнэлгийн захирал (Г.Оюунжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН